

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 16/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл(МБЗ) нь 2016 оны 4 дүгээр сарын 15, 28, 5 дугаар сарын 5-ны өдрүүдэд нийт 3 удаа хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан явуулав.

2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлогын газар(МБГ)-аас макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөх хэд хэдэн хувилбар, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг танилцуулав.

БНХАУ-ын аж үйлдвэр, барилгын салбар уналтанд орсон хэдий ч үйлчилгээний салбарын өсөлтийн нөлөөгөөр тус улсын эдийн засаг 2016 оны нэгдүгээр улирлын байдлаар 6.5%-н өсөлттэй гарлаа. Гэвч хөрөнгийн зах зээлийн тогтворгүй байдал, хөрөнгийн гадагшлах урсгал, ханшийн дарамт зэргээс шалтгаалсан гадаад валютын албан нөөц буурсантай холбоотой Хятадын эдийн засгийн өсөлт цаашид буурах төлөвтэй байна. Харин ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн хувьд газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаа, төсвийн алдагдал ихэссэн, мөнгөний бодлогын төлөв хатуу байгаа зэрэг нөхцөлүүдээс шалтгаалан өмнөх төсөөллөөс буурсан байна. Гадаад хүү өсөх, экспортын түүхий эдийн үнэ буурах, гадаад эрэлтийн төлөв муудаж байгаагаас шалтгаалан дотоод эдийн засагт эерэг нөлөө үзүүлж чадахааргүй байна.

Гадаад секторын таатай бус байдалтай холбоотойгоор манай эдийн засгийн өсөлт сүүлийн 3 жил дараалан буурч 2015 оны эцсийн байдлаар өмнөх оноос 2.3 хувиар өссөн. Уул уурхайн салбар 13 хувийн өсөлттэй, уул уурхайн бус салбар -0,8 хувийн уналттай байна. 2015 онд уул уурхай, ХАА, тээвэр, бусад үйлчилгээний салбаруудын өсөлт эдийн засагт эерэгээр нөлөөлсөн бол худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар сөрөг нөлөө үзүүллээ. Эрэлт талаас харвал эдийн засгийн өсөлтийг цэвэр экспорт, өрхийн хэрэглээ өсгөх нөлөө үзүүлсэн бол засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт бууруулах нөлөө үзүүлсэн байна.

2014 оны хоёрдугаар улирлаас хойш нийт болон суурь инфляци буурч байгаа хандлага ажиглагдаж байна. Нэгдсэн төсвийн зүгээс нийт эрэлтэд, улмаар инфляцид үзүүлэх дарамт бага байна. Харин улирлын чиг хандлага болон 2015 оны сүүлийн хагас жилд махны үнэ огцом буурсан нь тус бүтээгдэхүүний үнийг өсөх орон зайг бий болгож инфляцийг өсгөх нөлөө үзүүлсэн. Гэхдээ бусад бүтээгдэхүүний үнэ буурснаар ерөнхий инфляцийн түвшин буурсан хэвээр байна.

Энэхүү хурлын төгсгөлд МБГ-аас үүсээд байгаа эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бодлогын төлөвийг өөрчлөх 3 альтернатив хувилбаруудын нөлөөллийг тооцоолж, төсөөллийг танилцуулсан. Мөн төгрөгийн ханш, улсын валютын нөөцөд дарамт учруулах уламжлалт болон уламжлалт бус аливаа бодлого нь өнөөгийн нөхцөлд зохистой сонголт биш байгааг тодотгон уламжлалт бус аргаар аливаа төрлийн мөнгөний нийлүүлэлт хийхгүй байх, бодлогын хүүг өөрчлөхгүй 12 хувьд хадгалах бодлогын саналыг МБГ-аас дэвшүүлсэн. Энэ өдрийн хурлаас МБГ-аас гаргасан бодлогын саналыг дэмжих болон шүүмжлэх багийг томиллоо.

МБЗ-ийн 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар МБЗ-ийн гишүүд Бодлогын саналыг шүүмжлэх, дэмжих багууд өөрсдийн үндэслэлүүдээр хэлэлцүүлэг өрнүүлээ.

МБГ-аас гаргасан саналыг дэмжсэн гишүүд дунд болон урт хугацаанд Засгийн газар ба хувийн хэвшлийн зээл, бондын эргэн төлөлт хийгдэх, экспортын бүтээгдэхүүний гадаад эрэлт бага түвшинд хадгалагдах, ойрын 1-3 жилд уул уурхайн түүхий эдийн үнэ сэргэх хүлээлтгүй байгаа зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцэл алдагдалтай, валютын нийлүүлэлт дутагдалтай байгаа болон нийт эрэлтийг дэмжих төгрөгийн санхүүжилт нэмэгдэхээр хүлээгдэж байгаа өнөө үед Бодлогын хүүг бууруулснаар төгрөгийн өгөөж буурч болзошгүй. Үүнээс улбаалан хадгаламж төгрөгөөс гадаад валютад хөрвөх эрсдэлтэй байна. Валютын ханш сулрах нь банкуудын гадаад валютын зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх ба импортын барааны инфляцийг нэмэгдүүлэх эрсдэл учруулж болзошгүй зэрэг үндэслэлийг гаргаж байв. Мөн гадаад эрэлт буурсан өнөө үед МУ-ын уул уурхайн салбар нь мөнгө, зээлийн бодлогоор өсөхгүй, иргэдийн орон сууц худалдан авах эрэлт тогтворжсон тул барилгын салбарт цаашид өсөлт гарах хүлээлт ажиглагдахгүй, өрх, аж ахуйн нэгжүүдийн орлого буурч байгаатай холбоотой худалдан авалт нэмэгдэхгүй байгаа зэргээс шалтгаалан худалдааны салбар буурах хүлээлтэй байна. Иймд бодлогын хүүг бууруулсан ч эдийн засагт гарах эерэг өөрчлөлт багатай гэсэн байр суурийг илэрхийлэв.

Зарим гишүүд мөнгөний бодлогын хүүтэй үл хамаарах уламжлалт бус бодлогын хэрэгслүүдийг хэрэгжүүлж буй үед бодлогын хүүг хэвээр үлдээх, бууруулах, өсгөх нь үр нөлөө хязгаарлагдмал юм. Иймд шат дараатайгаар уламжлалт бус мөнгөний бодлогоос гарах хэрэгтэй гэж үзэв.

Мөнгөний бодлогын хэлтсийн саналыг шүүмжлэх гишүүд хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин сүүлийн 9 сарын турш зорилтот 7%-ийн түвшнээс доогуур хадгалагдаж, 2016 оны төгсгөлд зорилтот түвшнээс бага байхаар хүлээгдэж байгаа нь мөнгөний бодлогын тэлэх орон зайг нэмэгдүүлж байна. Цаашлаад дунд хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт сэргэх, улмаар сэргэсэн түвшиндээ хадгалагдах нөхцөл бүрдсэн нь макро эдийн засгийн орчин тогтворжих хандлагыг илэрхийлж байна. Өнгөрсөн оны 12-р сард хийгдэж байсан төсөөллөөр төлбөрийн тэнцлийн суурь төсөөлөл 1.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан бол одоогийн төсөөллөөр 126 сая ам.долларын ашигтай гарахаар байна.

Иймд төлбөрийн тэнцлийн ихээхэн хэмжээний алдагдлаас алдагдалгүй хандлага руу орж ирж байгаа орчин, инфляцийн шинэчилсэн төсөөлөл ч зорьж буй түвшнээс доогуур байгаа нөхцөлд эрсдлээс шалтгаалан бодлогын хүүг хэвээр хадгалъя гэдэг нь өмнөх бодлогын хүүний шийдвэртэй нийцгүй байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийг харахад бодлогын хүүг өөрчилсөн сүүлийн 5 шийдвэрүүдээс хойших хугацаанд зээлийн өсөлт, M2 мөнгөний агрегатын өсөлт сөрөг хэвээр байна. Иймд мөнгөний бодлогын хүүг бууруулж хувийн хэвшлийн зээлийг алгуур нэмэх нь чухал юм.

2016 оны эхнээс төсвийн орлого тасалдаж, зардал нэмэгдсэнээр төсвийн алдагдал ихэсч байна. Засгийн газар төсвийн алдагдлаа бууруулж, зарцуулалтаа хумихгүй нөхцөлд бодлогын хүүг бууруулах нь эрсдэлтэй алхам. Төсөв талаасаа харвал бодлогын хүүг бууруулах нөхцөл бүрдээгүй хэдий ч нийт эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний агрегатууд, гадаад орчин, инфляцийн төсөөллөөс үүдэн 1-р сард гаргасан шийдвэртэй нийцтэйгээр мөнгөний бодлогын төлвийг зөөлрүүлэх нь зүйтэй гэж үзэж байв.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогыг хэвээр үлдээх саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсний эцэст Мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, Бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулах томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүдийн олонхын саналаар Бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулахаар шийдвэрлэв.

Бодлогын хүүг бууруулахад инфляцийн нам тогтвортой түвшин голчлон нөлөөллөө. 2016, 2017 онд инфляци зорилтот түвшнээс бага түвшинд хадгалагдах төсөөлөлтэй байна. Эдийн засгийн орчинд мөнгөний нийлүүлэлт, зээлийн хэмжээг нэмэгдүүлэхэд таатай орчин бий

болсон бөгөөд үүнд бодлогын хүүний бууралт эерэг нөлөө үзүүлнэ. Мөн сүүлийн жил хагасын хугацаанд гадаад худалдааны тэнцэлд гарсан өөрчлөлт төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлж байна. Цаашид энэ нөлөө хадгалагдахаар байна. Иймд бодлогын хүүгээ бууруулах нь цаг үеэ олсон зөв шийдвэр гэдэг санал дээр зөвлөлийн гишүүд санал нэгдэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулж, 10.5 хувь болгох шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын шийдвэрийг 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.